

10-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТ-2024

ХУВИЛБАР А

Хугацаа-80 минут Нийт-100 оноо

1. “Нийгмийн бүтэц гэдэг нь нийгмийн хэсэг элементүүдийн хооронд бэхэжсэн тогтвортой харилцаа холбоог хэлнэ” гэж хэн хэлсэн бэ?

- а. О. Конт б. В. Занден в. К. Маркс г. М. Вебер

2. Санамсаргүй түүврийн аргыг ашиглан, олон хүн амыг хамруулан судлагдахууны дүр төрхийг тодорхойлох, шалтгаант хамаарлыг тодорхойлох зорилготой бол аль аргыг сонговол оновчтой вэ?

- а. Ажиглалтын арга б. Асуулгын арга в. Ярилцлагын арга г. Туршилтын арга

3. Аль нь ил чиг үүрэг вэ?

- а. Үйлдэгч урьдчилан тооцоолоогүйгээр бий болсон үр дагавар
б. Тухайн үйлдлийг гүйцэтгэгчээс мэдэж тооцоолсон үр дагавар
в. нийгмийн үйлдэгчийн тодорхой үр дагаварт хүрэхээр зорьж хийсэн үйлдэл нь зорьсоныхоо эсрэг үр дагаварт хүрэх

4. Нийгмийн институт хэмээх ойлголт аль нь биш вэ?

- а. Нийгмийн бүтцийг макро түвшинд хийсвэрлэн илэрхийлж буй ойлголт
б. Хувь хүний үйлдэл нийгмийн институтийн нөлөөн дор явагддаг.
в. Нийгмийн тодорхой хэрэгцээг хангахын төлөө хэм хэмжээтэй , дахин давтагддаг үйлдлээрээ холбогдсон нийгмийн байр сууриудын нэгдэл
г. Хүмүүсийн үйлдэл , тэдгээрийн хоорондын харилцаанд илрэх ба тодоорхой орон зай, цаг хугацаанд тогтвортойгоор буюу дахин давтагдаж байдаг

5. Зөв харгалзуулаарай

А. Ойр дотнынхонтойгоо харилцах, дуурайх, дүрд тоглох, багаар тоглох, суралцах зэргээр нийгэмшин хөгждөг. 1. Ахмад настны нийгэмшилт

Б. Шинэ байр суурь, үүргийн шаардлага, арга барил эзэмших, туршлага хуримтлуулах, зайлшгүй болон гэнэт тохиолдох хямралыг даван туулах байдлаар нийгэмшдэг. 2. Дахин нийгэмшилт

В. Байр суурь , үүргийн хүлээлт нь тодорхойгүй тул бага өөрчлөгддөг, бие сэтгэхүйн чадамж буурсантайгаа зохицон, даван туулах байдлаар нийгэмшдэг. 3. Хүүхэд насны нийгэмшилт

Г. Бүх хүний нийгэмшилт өгсөх замаар явагддаггүй. Урьд өмнө тогтсон үнэт зүйл, мэдрэмж, зан үйлийн загвараа эрс өөрчлөх нь бий. 4. Насанд хүрэгсдийн нийгэмшилт

6. Соёл буюу culture гэдэг нь colere гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд гэсэн утгатай.

- а. Соёл б. соёолуулан боловсруулах, хөрс боловсруулах
в. оюуны үнэт зүйлс г. материаллаг үнэт зүйлс

7. Бүхий л соёлд нийтлэг байдаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг юу гэж нэрлэдэг вэ?

- а. Соёлын хэм хэмжээ б. соёлын нийтлэг в. соёлын түгээмэл г. Соёлын нэгдэл

8. Хэлний гол онцлог шинжүүдээс аль нь биш вэ?

- а. Тухайн ард түмний түүх соёлыг хадгалан дамжуулах үндсэн арга хэрэгсэл
б. Тухайн үндэстэн угсаатныг нэгтгэж , нийгэм болгож байдаг
в. Соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулах, соёлыг бүтээх, илтгэх арга хэрэгсэл
г. Хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ

9. Аливаа зүйлийн үнэн эсэхийг шалган тодорхойлох, туслах арга, аргачлал, зарчимд тулгуурладаг нь мэдлэгийн аль төрөл вэ?

а. Шашин б. домог в. философи г. шинжлэх ухаан д. Урлаг

10. Зөв харгалзуулаарай.

А. Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн \ хэл , бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт\ нэгдэл мөн

1. Р. Бенекдит

Б. Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль , зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэл юм.

2. А. Гидденс

В. Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж , өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг.

3. Э. Тейлор

Г. Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг, хэм хэмжээ болон материаллаг баялгыг багтаадаг цогц ойлголт

4. Э. Кассирер

11. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн онд батлагдсан бэ?

а. 1945 б. 1946 в. 1947 г. 1948

12. Хэн боолуудыг чөлөөлөн , бүх хүмүүс ижил эрхтэй гэдгийг гүүхэнд анх удаа тунхаглан шавар бортого дээр бичиж үлдээсэн бэ?

а. Эртний Грекийн Софистууд

б. Мартин Лютер Кинг

в. Аугаа Сириус

г. Элеанор Рузвельт

13. Хүн бүр хүмүүн болохынхоо хувьд адил үнэ цэнтэй бөгөөд тодорхой үндсэн эрх, эрх чөлөөг эдэлдэг тухай ойлголт аль нь вэ?

а. Хүний эрх б. эрх чөлөө в. хүний эрхэм чанар г. нэр төр

14. “ Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон, худал мэдээллийн нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянга, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

а. Үндсэн хууль

б. Зөрчлийн тухай хууль

в. Эрүүгийн хууль

г. Хүний эрхийн түгээмэл тунхаглал

15. Иргэн хүн захиргааны байгууллагатай харилцах үндсэн хэлбэрийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

а. гомдол гаргах

б. өргөдөл гаргах

в. нотлох баримт гаргах шалгуулах

г. санал, хүсэлт гаргах

16. Зөв харгалзуулаарай. /4 оноо/

А. Эрх зүйн бүрэн чадамж

1. 14-18 насны этгээд

Б. Эрх зүйн зарим чадамж

2. 7 хүртэлх насны хүүхэд болон сэтгэцийн өвтэй хүн

В. Эрх зүйн бүрэн бус

3. 18 наснаас дээш

Чадамж

Г. Эрх зүйн чадамжгүй

4. 7-14 насны этгээд

17. Зөв харгалзуулаарай

А. Гомдол

1. Захиргааны байгууллагын буруугаас иргэн , хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж , зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт

Б. Өргөдөл

2. Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг

Шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт

В. Хүсэлт

3. Байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр

Г. Захиргааны

шийдвэр буюу акт

4. Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар

болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт

18. Эдийн засгийн салбар дахь хуулиас гадуур болон нарийн үнэлж чаддаггүй, заримыг ерөөс үнэлэх боломжгүй үйл ажиллагааг юу гэж нэрлэдэг вэ?

а. хууль бус ажиллагаа

б. сүүдрийн эдийн засаг

в. зах зээлээс гадуурх үйл ажиллагаа

г. татвараас зугтсан үйл ажиллагаа

19. Английн эрдэстэн Оукен ажилгүйдлийн өсөлт , үйлдвэрлэлийн хэмжээ хоёрын хамаарлыг хэрхэн үзсэн бэ?

а. ажилгүйдэл 2% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 3% -иар буурна.

б. ажилгүйдэл 2% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2.5% -иар буурна.

в. ажилгүйдэл 3% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2% -иар буурна.

г. ажилгүйдэл 2% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 5% -иар буурна.

20. Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөгийг хэрхэн нэрлэх вэ?

а. ДНБ

б. ҮНБ

в. ҮЦБ

г. Нэрлэсэн ДНБ

21. ДНБ-ний тодорхойлолтод өгөх тайлбарт илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

а. Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэгдсэн байх

б. Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх

в. Үйлдвэрлэл нь ямар нэгэн төлбөр шаардаагүй байх

г. Эцсийн бараа үйлчилгээний өртөг байх

22. Хурдтай инфляцийн үед хэн хожиж болох вэ?

а. төрийн албан хаагчид

б. банкинд хадгаламжтай хүн

в. мөнгөө бэлнээр хадгалж байгаа хүн

г. банкнаас зээл авсан хүн

23. Ажилгүйдлийн хэлбэрүүдийн зөв харгалзуулаарай:

А. Эдийн засгийн уналттай холбоотой үүссэн

Ажилгүйдэл

1. Улирлын ажилгүйдэл

Б. Шилжих хөдөлгөөнтэй холбоотой үүссэн ажилгүйдэл

2. Мөчлөгийн ажилгүйдэл

В. Эдийн засаг дахь ажил мэргэжлийн эрэлтийн

өөрчлөлттэй холбоотой үүссэн ажилгүйдэл

3. Шилжилтийн ажилгүйдэл

Г. Улирлын үйл ажиллагаатай үүссэн

4. Бүтцийн ажилгүйдэл

24. Зөв харгалзуулна уу.

А. Инфляци

1. Инфляцийн хурд 54,2%

Б. Мөлхөө инфляци

2. Мөнгөний ханш өсөх үзэгдэл

В. Цогио инфляци

3. Мөнгөний ханш унах үзэгдэл

Г. Дефляци

4. Инфляцийн хурд 123,7%

25. Шинэ үндсэн хуулийг хэдийн баталсан бэ?

а. 1989.12.10

б. 1992.01.13

в. 1994.01.13

г. 1995.11.26

26. “ Улс төр бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглан албадлагын арга хэрэгслийн цогц юм” гэж хэн тодорхойлсон бэ?

а. А. Линкольн

б. Р.Даль

в. Н Макиавелли

г. Д.Истон

27. Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтныг сонгож , түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлдэг хэлбэр аль нь вэ?

а. шууд ардчилал

б. төлөөллийн ардчилал

в. төрийн ардчилал

г. ардчилал

28. Монгол улсын засгийн газар бол төрийн.....байгууллага мөн.
 а. хууль тогтоох б. гүйцэтгэх в. шүүх д. Хянах
29. Авлигын төсөөллийн индексээр Монгол улс авлигад өртсөн орнуудын тоонд багтаж, дэлхийн 176 орноос 87 –д эрэмблэгдэж байна гэсэн судалгааг ямар байгууллага гаргасан бэ?
 а. “Transparency International” б. АТГ в. Фрийдом хаус г. УТБА
30. Төрийн эрх мэдлийг хуваарилах онолын гол төлөөлөгчдийг нэрлэнэ үү.
 а. Д.Макиавелли , Д.Истон б. А. Линкольн, В.Черчилль
 в. Р. Даль, Д.Макиавелли г. Ш. Моньтеско, Ж.Локк
31. Ардчилалын зарчмуудыг зөв харгалзуулна уу?
 А. Иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих , тэдний үйл ажиллагааг сайжруулах, авилга, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлдэг 1. Хууль дээдлэх зарчим
 Б. Иргэдэд адил тэнцүү боломж олгодог ба энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм зарчим 2.Цөөнхийг хүндэтгэх
 В. Шударга ёсыг тогтоох , төр ба иргэний хоорондын харилцаанд үйлчилж байх шаардлагатай 3. Шударга байх зарчим
 Г. Олонх нь удирдан захирч цөөнхийг эрхийг хуулиар болон хуулийн байгууллагаар дамжуулан хамгаалдаг 4. Нээлттэй зарчим
32. Ардчилалын үнэт зүйлсийг зөв харгалзуулна уу?
 А. Хүн бүр эрх тэгш, чөлөөтэй байх эрхтэй, эрхэм зэрэгтэй төрсөн 1. Олон намын тогтолцоо
 Б. Сонгуульд саналаа өгөх, нэрээ дэвшүүлэх, сонирхлын бүлэгтэй хамтран ажиллах, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага,албан тушаалтанд хандан захидал бичих, санал хүсэлт тавих зэрэг олон хэлбэрээр хэрэгжинэ ёс 2.Нийтэд тайлагнах, ил тод байх
 В.Сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан нь өөрсдийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээнэ. Тэд өөрсдийн төлөө бус ард олны хүсэл, сонирхол, эрх ашигт нийцүүлэн ажил үүрэг гүйцэтгэж, шийдвэр гаргадаг оролцоо 3.Иргэдийн улс төрийн
 Г. Нэгээс дээш нам улс төрийн амьдралд идэвхтэй оролцож, хөгжлийн бодлогоор өрсөлдөх, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. 4. Хүний эрх, эрх чөлөө
33. Монгол улс олон улсын эрх зүйн хүрээнд де-факто байх статусыг хэдэн он хүртэл эдэлж байсан бэ?
 а. 1945 он хүртэл б. 1956 он хүртэл в. 1961 он хүртэл г. 1990 он хүртэл
34. Мөнхийн дайсан гэж байдаггүй, мөнхийн хөрш гэж байдаг” ХХ зууныз шилдэг улс төрч хэлсэн байдаг. Хэн бэ?
 а. В.Черчилл б. М. Лютер в. Н.Мандела г. Р. Ганди
35. Аль нь Монгол улсын хоёр хөрштэйгөө харилцах зарчим бэ?
 а. Хүмүүнлэгийн б. улс төрийн в. Соёл, боловсролын г. тэнцвэртэй ,найрсаг
36. Олон улсын засгийн газар хоорондын хамгийн түгээмэл, нээлттэй, улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааны хамгийн олон салбар чиглэлийг хамардаг байгууллага аль нь вэ?
 а. ОУВС б. дэлхийн банк в. Европын холбоо г. НҮБ
37. Гадаад бодлогын шийдвэр гаргах дарааллаас илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

- а. мэдээлэл, цуглуулах, дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах
- б. дээд байгууллагад шийдвэр гаргах төсөл боловсруулж оруулах
- в. шийдвэр гаргах
- г. санал боловсруулах

38. Улс орнуудын хооронд гэрээ хэлэлцээр байгуулах, элч төлөөлөгч солилцох, төрийн тэргүүний айлчлал, хамтарсан уулзалт, хурал зөвлөгөөн хийх зэрэглэл талт үйл ажиллагаа нь ямар чиглэлийн гадаад харилцаа вэ?

- а. эдийн засгийн
- б. боловсролын
- в. хүмүүнлэгийн
- г. улс төрийн

39. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчим, агуулгыг зөв харгалзуулаарай.

А. Үндэсний эрх ашиг аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах

1. Тэнцвэртэй байх

Б. Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх

2. Олон тулгуурт байх

В. Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах байх

3. Үндэсний эрх ашигт нийцсэн

Г. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн эдийн засаг болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэх

4. Прагматик байх

40. Олон улсын харилцаан дахь ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

А. Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах... бодлого баримтлана

1. Эдийн засгийн олон тулгуурт бүтэц

Б. Эдийн засгийн судалгаа тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай бүтцийг бий болгоно

2. Транзит Монгол

В. Үндэсний сонирхлыг тусгасан зорилгуудыг тодорхойлох, бусад улс, олон улсын байгууллагад нөлөөлөх замаар тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

3. Эдийн засгийн аюулгүй байдал

Г. Манай улсын төмөр замын тээвэр нь Ази, Европыг холбосон олон улсын тээврийн коридорын нэг болохын хувьд БНХАУ, ОХУ, Европ болон буцах чиглэлд дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх төмөр замын салбарын хөгжилд онцгой ач холбогдолтой

4. Улс төрийн гадаад бодлого

ТҮЛХҮҮР НИЙГЭМ СУДЛАЛ-2024

| № | Хариулт | Оноо |
|----|-------------|----------|
| 1 | Б | 2 оноо |
| 2 | Б | 2 оноо |
| 3 | Б | 2 оноо |
| 4 | В | 2 оноо |
| 5 | 1в 2г 3а 4б | 4 оноо |
| 6 | Б | 2 оноо |
| 7 | В | 2 оноо |
| 8 | Г | 2 оноо |
| 9 | Г | 2 оноо |
| 10 | 1в 2г 3б 4а | 4 оноо |
| 11 | Г | 2 оноо |
| 12 | В | 2 оноо |
| 13 | В | 2 оноо |
| 14 | Б | 2 оноо |
| 15 | В | 2 оноо |
| 16 | 1в 2г 3а 4б | 4 оноо |
| 17 | 1а 2в 3г 4б | 4 оноо |
| 18 | Б | 2 оноо |
| 19 | Г | 2 оноо |
| 20 | Б | 2 оноо |
| 21 | В | 2 оноо |
| 22 | Б | 2 оноо |
| 23 | 1г 2а 3б 4в | 4 оноо |
| 24 | 1в 2г 3а 4б | 4 оноо |
| 25 | Б | 2 оноо |
| 26 | В | 2 оноо |
| 27 | Б | 2 оноо |
| 28 | Б | 2 оноо |
| 29 | А | 2 оноо |
| 30 | Г | 2 оноо |
| 31 | 1в 2г 3б 4а | 4 оноо |
| 32 | 1г 2в 3б 4а | 4 оноо |
| 33 | в | 2 оноо |
| 34 | а | 2 оноо |
| 35 | г | 2 оноо |
| 36 | г | 2 оноо |
| 37 | г | 2 оноо |
| 38 | г | 2 оноо |
| 39 | 1г 2а 3б 4в | 4 оноо |
| 40 | 1б 2г 3а 4в | 4 оноо |
| | Нийт | 100 оноо |
| | | |

